



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/263

Эрдэнэт

Арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/а/, 29.2, Монгол улсын Засгийн газрын 2017 оны 112 дугаар тогтоолын 3.2.1.6, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит III хуралдааны 01 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн VI хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Орхон аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-ний 1.1.9.2, 1.1.9.4, аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн 1.1.9.4 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/166 дугаар тушаал, "Элэгний вирусгүй Эрдэнэт хот" аяныг зохион байгуулах ажлын хүрээнд "В" вирусийн халдвартай эхээс хүүхдэд халдвар дамжихаас сэргийлэх зорилгоор төрсний дараа 24 цагийн дотор нярайд гепатитийн "В" вирусийн эсрэг вакциныг иммуноглобулинтай хавсарч хэрэглэж дархлаажуулснаар эхээс хүүхдэд "В" вирусийн халдварын тархалт болон өвчлөл бууруулах "ЭЛЭГНИЙ В ВИРУСИЙН ХАЛДВАРГҮЙ НЯРАЙ" арга хэмжээг зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар баталж "Эрдэнэтийн эрүүл иргэн" ТББ-тай 2017 оны 05 дугаар сарын 09-ний өдрөөс нэг жилийн хугацаатай хамтран ажиллах гэрээ байгуулан төрийн зарим үйлчилгээг гүйцэтгүүлсүгэй.

2.Шаардагдах зардал 29350000/ Хорин есөн сая гурван зуун тавин мянган/ төгрөгийг 2017 онд зарцуулах төсөл хөтөлбөрийн Элэгний вирусгүй Эрдэнэт хот аяныг зохион байгуулах, үйл ажиллагааг дэмжих зардлаас гаргахыг Санхүү төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.


3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг "Элэг бүтэн Монгол" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсэг /н.Түвшинжаргал/, Нийгмийн бодлогын хэлтэс /н.Бумансор/, Эрүүл мэндийн газар /н.Баттүвшин/, Бүсийн оношлогоо эмчилгээний төв /н.Батсүх/ нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 9-ны өдрийн 126 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



**“ЭЛЭГНИЙ “В” ВИРУСИЙН ХАЛДВАРГҮЙ НЯРАЙ” АРГА ХЭМЖЭЭГ
ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ САНХҮҮЖИЛТ**

№	Зардлын утга	Нэгж үнэ	Тоо хэмжээ	Нийт дүн
ГАРЫН АВЛАГА				
4	Хэвлэмэл материал	400	5,000	2,000,000
5	Анонс, постер	10	35,000	350,000
	Нийт			2 350 000
ИММУНОЛОГЛОБУЛИН				
7	Зориулалтын хөргөгч	1,000,000	1	1,000,000
8	Иммуноглобулин	85,000	300	25,500,000
9	Зориулалтын цүнх	200,000	1	200,000
10	Тарилгын бусад хэрэгсэл	300,000	1 багц	300,000
	Нийт			27000 000
	Бүгд			29 350 000